

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

#### **1/13<sup>2</sup> дугаар зүйл:**

##### **“13<sup>2</sup> дугаар зүйл. Цэргийн тагнуулын байгууллага**

13<sup>2</sup>.1. Цэргийн тагнуулын байгууллага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдлагыг Үндэсний аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр хангах үндсэн чиг үүрэг бүхий цэргийн байгууллага мөн.

13<sup>2</sup>.2. Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар байгуулж, өөрчилж, татан буулгана.

13<sup>2</sup>.3. Цэргийн тагнуулын байгууллагын дүрэм, ажиллах журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батална.

13<sup>2</sup>.4. Цэргийн тагнуулын байгууллага үйл ажиллагаагаа явуулахад Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

13<sup>2</sup>.5. Цэргийн тагнуулын байгууллага бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга батална.

#### **2/13<sup>3</sup> дугаар зүйл:**

##### **“13<sup>3</sup> дугаар зүйл. Хилийн тагнуулын байгууллага**

13<sup>3</sup>.1. Хилийн тагнуулын алба нь хил хамгаалах байгууллагын удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээгээр хангах үндсэн чиг үүрэг гүйцэтгэнэ.

13<sup>3</sup>.2. Хилийн тагнуулын албаны бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**13<sup>3</sup>.3.Хилийн тагнуулын албаны дүрэм, ажиллах журмыг хил хамгаалах байгууллагын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар батална.**

**13<sup>3</sup>.4.Хилийн тагнуулын алба үйл ажиллагаагаа явуулахдаа Монгол Улсын хилийн тухай хууль болон энэ хуулийн 13<sup>2</sup>.4-д заасан хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.**

**13<sup>3</sup>.5.Хилийн тагнуулын алба бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Хил хамгаалах байгууллагын дарга батална.**

### **3/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг**

**14.1.Тагнуулын ерөнхий газар нь дарга, тэргүүн дэд дарга, дэд даргатай байна.**

### **4/14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг**

**14.3.Тагнуулын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, дэд даргаар төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, гүйцэтгэх ажлын мэдлэг, туршлагатай, сүүлийн 5 жил төрийн албанд тасралтгүй ажиллаж байгаа Монгол Улсын иргэнийг Тагнуулын ерөнхий газрын даргын санал болгосноор Засгийн газар б жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.**

### **5/14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсэг**

**14.10.Тагнуулын ерөнхий газрын даргын түр эзгүйд түүний бүрэн эрхийг тэргүүн дэд дарга хэрэгжүүлнэ. Тагнуулын ерөнхий газрын дарга, тэргүүн дэд даргын түр эзгүйд тэдгээрийн бүрэн эрхийг дэд дарга хэрэгжүүлнэ.”**

**2 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-14.7 дахь хэсгийн “газрын дарга” гэсний дараа “тэргүүн дэд дарга,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4 дэх хэсгийн “дарга,” гэсний дараа “тэргүүн дэд дарга,” гэж тус тус нэмсүгэй.**

**3 дугаар зүйл.Тагнуул байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

### **“1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг**

**9.1.Монгол Улсын тагнуулын байгууллагын тогтолцоо нь тагнуулын төв байгууллага /цаашид “Тагнуулын ерөнхий газар” гэх/, цэргийн тагнуулын байгууллага, хилийн тагнуулын байгууллага, тэдгээрийн салбар, нэгжээс бүрдэнэ.”**

**4 дүгээр зүйл.Тагнуулын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.1” дэх хэсгийн дугаарыг “14.2” гэж, мөн зүйлийн “14.2-14.7” дахь хэсгийн дугаарыг “14.4-14.9” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “28.2.3-т” гэснийг “57.2.3-т” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “36.4, 36.6-д” гэснийг “39.4, 39.7-д” гэж тус тус өөрчилсүгэй.**

**5 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “цэрэг-стратегийн тагнуул, хилийн тагнуул” гэснийг хассугай.**

**6 дугаар зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсэг, 10.10.6 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.14, 11.1.15 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.17, 15.1.18 дахь заалт, 15.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг